



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/522

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Оргил багийн нутаг дэвсгэрт баригдсан "Минж" зочид буудлын барилга байгууламжийн угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Д.Отгонжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	П.Аззаяа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн улсын байцаагч)
	Н.Пүрэвдулам (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Г.Золзаяа (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)

2.

- Н.Золжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)
Э.Энхболд ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын захирал)
Д.Баярчулуун ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн реле хамгааллын инженер)
Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
Ш.Ариунаа (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн зөвлөлийн дарга)
Б.Рэнцэндорж ("Геоконстракшн" ХХК-ийн захирал) (зохиогч)
Х.Лхагвацэрэн ("Ланз" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Б.Батсүх ("Булган номин уул" ХХК-ийн захирал) (захиалагч)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн дотор танилцуулахыг комисс (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ